<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>843,416,400.00</b>	<b>778,869,200.59</b>
320001	Орон нутгийн төсвөөс	794,003,700.00	729,456,500.59
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	49,412,700.00	49,412,700.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,600,000.00</b>	<b>16,736,858.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,600,000.00	16,736,858.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>240,496,900.00</b>	<b>106,787,214.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,952,000.00	106,787,214.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	166,544,900.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	95,463,043.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	76,784,138.57
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>689</b>	<b>689</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6</b>	<b>6</b>
610001	Төсвийн байгууллага	6	6
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>106.5</b>	<b>106.5</b>
620001	Удирдах ажилтан	13	12
620002	Гүйцэтгэх ажилтан	68.5	67.5
620003	Үйлчлэх ажилтан	22	24
620004	Гэрээт ажилтан	3	3
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>470</b>	<b>470</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>390</b>	<b>390</b>
630001	Төрийн өмчит ЕБС	390	390
630002	Хувийн ЕБС	0	0
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>80</b>	<b>80</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	80	80
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>106.5</b>	<b>106.5</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	33	33
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17	17
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	33.5	33.5
650010	Гэрээт ажилтан	0	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>258,158,708.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>258,158,708.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>227,578,172.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>46,208,288.80</b>
210101	Үндсэн цалин	25,572,854.50
210102	Нэмэгдэл	4,035,434.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0
210104	Урамшуулал	16,600,000.00

210105	Гэрээт ажлын хөлс	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,757,358.17</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,446,790.00</b>
210401	Бичиг хэрэг	194,000.00
210402	Тээвэр, шатахуун	263,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	365,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,623,890.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>68,327,530.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,327,530.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,728,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,510,300.00
210604	Урсгал засвар	2,218,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,374,838.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,374,838.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,734,568.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,234,568.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,580,536.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,400,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>180,536.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	180,536.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>264,532,250.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>264,532,250.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,634,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,665,464.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	216,265,984.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,966,802.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>6,373,541.03</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,373,541.03

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын Засаг дарга Б.Мөнхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 14-нөөс 2021 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, үе шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар хийж, ахлах аудитор П.Содном гүйцэтгэв.

Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Могод сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах

- Төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй шуурхай хүргэх
- Нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангах
- Шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, ололт амжилтыг урамшуулах, алдаа дутагдлыг засаж залруулах, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан байна.

### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,064,743.4 мянган төгрөгийн 2 хувь буюу 81,294.9 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 80 хувиар буюу 65035.9 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 116519.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 228795.6 мянган төгрөг болж, 112276.2 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт	Хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Төрийн сангийн харилцах	166,544.9	223,131.5	56,586.6	
Нэмэлт санхүүжилт		6,373.5	6,373.5	
<b>Замд яваа мөнгөн хөрөнгө</b>				
<b>Дүн</b>	<b>166,544.9</b>	<b>229,505.0</b>	<b>62,960.1</b>	

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 229,505.0 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны 146347.4 мянган төгрөг нь орон нутгийн орлогын давсан орлого 46823.8, орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх орлого малын хөлийн татвар 99523.6 мянган төгрөг байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 7763.9 мянган төгрөгийн үлдэгдэл нь хэрэгжээгүй төөл арга хэмжээ, сум хөгжүүлэх сангийн 31621.1, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 29548.1, хүн эмнэлгийн харилцах дансанд 6970.1 мянган төгрөг тус тус төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

#### 3.5.2 Авлага

~~Авлага Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 229842.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 265344.5 мянган төгрөг болж, 35502.4 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	9864.9	60895.5	51030.6
Хүмүүсээс авах авлага	146409.3	192626.9	46217.6
Зээлийн авлага			
<b>Дүн</b>	<b>156274.3</b>	<b>253522.5</b>	<b>97248.2</b>

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагаас авах авлагад ЗДТГ-ын 4798.8 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн дансны татан төвлөрүүлсэн авлагаар тусгасан, хүүхдийн цэцэрлэгийн 1741.5 мянган төгрөгийн авлага нь өмнөх оны тоглоомын авлагын үлдэгдэл, Хүн эмнэлгийн 54355.2 мянган төгрөгийн авлага нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс авах авлага байна.

Хувь хүмүүсээс авах авлагын 187966.7 мянган төгрөг нь сум хөгжүүлэх, ЖДҮДС -гийн 4660.2 мянган төгрөг нь баг хөгжүүлэх сангаас шилжиж ирсэн зээлийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Тоглоом худалдах, худалдан авах гэрээ зөрчин бараа бүтээгдэхүүнээ хүлээн аваагүй байж санхүүжилтийг нь олгосон, авлага үүсгэсэн /Хүүхдийн цэцэрлэг/

### 3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ Эхний үлдэгдэл 215,658.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 335,143.3 мянган төгрөг болж, 119.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	10670.9	31528	20857.1
Бичиг хэрэг	5397.9	9492.6	4094.7
Аж ахуйн материал	30099.1	63089.9	32990.8
Сэлбэг хэрэгсэл	2636.5	2636.5	0
Түлш, шатах тослох материал	1300	1310	10
Барилгын засвар		928.8	928.8
Хүнсний материал	7457.8	8310.9	853.1
Бусад хангамж	156833.4	206161.4	49328
Нөөцын бараа		10360	10360
Мал амьтад	1263.2	1325.2	62
<b>Дүн</b>	<b>215658.8</b>	<b>335143.3</b>	<b>119484.5</b>

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 302533.7 хандив тусламжаар 30520.1, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 11881.9, бусад эх үүсвэрээс 184807.4 мянган төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 386587.6 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 10410.0, бусад болон акталж устгасан 13234.9 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж хөрөнгийн үлдэгдэл бүх дансанд өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг байгууллагаар харуулбал

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл байгууллагаар

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	1553.2	8271.9	6718.7
2	ЗДТГ	52952.3	59261.7	6239.4
3	Хүн эмнэлэг	30846.9	120142	89295.1
4	Цэцэрлэг	41103.2	43177.9	2074.7
5	Сургууль	61011.2	78138.7	17127.5
6	Соёлын төв	14815.9	15860.9	1045
7	Сум хөгжүүлэх сан	13350		-13350
	ЖДҮДС		10360	10360
	<b>Дүн</b>	<b>215632.7</b>	<b>335143.1</b>	<b>119510.4</b>

Нийт бараа материалын 35.8 хувийг Эрүүл мэндийн төв, 23.3 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 17.6 хувийг ЗДТГ, 12.8 хувийг хүүхдийн цэцэрлэг, 4.7 хувийг соёлын төв, 2.5 хувийг ИТХ-ын хөрөнгө тус тус эзэлж байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 4,951,522.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,013,306.9 мянган төгрөг болж, 61,784.0 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Үндсэн хөрөнгийн 75.2 хувийг барилга байгууламж, 10.0 хувийг машин тоног төхөөрөмж, 4.9 хувийг авто тээврийн хэрэгсэл, 5.3 хувийг тавилга эд хогшил, 2 хувийг бусад биет бус хөрөнгө, 1.5 хувийг бусад үндсэн хөрөнгө, 0.8 хувийг ном эзэлж байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3841431.6	3768399.6	-73032
Авто тээврийн хэрэгсэл	246230.7	246230.7	0
Машин тоног төхөөрөмж	417567.2	499787.3	82220.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	221124.2	267718.8	46594.6
Бусад үндсэн хөрөнгө	73892.3	73892.3	0
Ном	36132.9	38334.2	2201.3
Программ хангамж	4400	8200	3800
Бусад биет бус хөрөнгө	110744	110744	0
<b>Дүн</b>	<b>4,951,522.9</b>	<b>5013306.9</b>	<b>61784</b>

*Эх сурвалж:* Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 133680.6, балансаас балансад шилжүүлэн авсан 2201,2, бусад 25640.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 109212.9 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	14,954.30	19848.1	4,893.80
2	ЗДТГ	2,424,959.00	2363782.5	(61,176.50)
3	Хүн эмнэлэг	703,167.90	759263.1	56,095.20
4	Цэцэрлэг	514,814.50	519814.5	5,000.00
5	Сургууль	1,062,438.00	1112414.5	49,976.50
6	Соёлын төв	231,189.20	238184.2	6,995.00
	<b>Дүн</b>	<b>4,951,522.90</b>	<b>5,013,306.90</b>	<b>61,784.00</b>

Үндсэн хөрөнгийн 47.1 хувийг сумын ЗДТГ, 22.2 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 15.1 хувийг Эрүүл мэндийн төв, 10.4 хувийг хүүхдийн цэцэрлэг, 4.8 хувь нь соёлын төвийн үндсэн хөрөнгө байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 3525.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5641.7 мянган төгрөг болж, 2115.9 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон өглөг	161.6	0	-161.6

Бараа үйлчилгээний зардлын өглөг			0
Байгууллагаас авах авлага			0
Хүмүүст өгөх өлөг			0
<b>Дүн</b>	<b>161.6</b>	<b>0</b>	<b>-161.6</b>

*Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Оны эхний үлдэгдэл 161.6 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж тайлант оны эцэст өглөгийн үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6172412.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6242107.3 мянган төгрөг болж, 69694.9 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+/ бууралт /-/</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	<u>1208784.1</u>	<u>1208784.1</u>	<u>0</u>
<u>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</u>			<u>0</u>
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	<u>1689534.8</u>	<u>1719622.2</u>	<u>30087.4</u>
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	<u>1442418.3</u>	<u>1442906.4</u>	<u>488.1</u>
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>0</u>
<b><u>Дүн</u></b>	<b><u>4,340,737.20</u></b>	<b><u>4,371,312.70</u></b>	<b><u>30,575.50</u></b>

*Эх сурвалж: Могод сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4340737.2 мянган төгрөг болж 30575.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 4336652.9 мянган төгрөг болж 228.7 мянган төгрөгөөр буурсан нь сумын Эрүүл мэндийн төв дахин үнэлгээтэй хөрөнгө акталж түүний дахин үнэлгээ буурснаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 5672.9 сая төгрөг болж 74867.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 209,877.2 мянган төгрөгийн татварын орлого, 308,408.8 мянган төгрөгийн татварын бус орлого, 2,725,852.3 мянган төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,244,138.3 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна. Тусламж санхүүжилтийн орлогын 1,247,094.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 259,166.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 1,148,499.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 71,092.1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Сумын ИТХ-ын 2021 оны 08 дүгээр сарын 03-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор сумын 2021 оны төсвийн жилд зарцуулах төсвийг 2359607.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2145304.4 мянган төгрөг буюу 90.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

## Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын ИТХ-ын 2021 оны 08 дүгээр сарын 03-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор сумын 2021 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 198,336.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр тайлант онд 219,562.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 107.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мян.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>	203,336.90	219,562.70	16,225.80	107.98
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>198,336.90</b>	<b>216,380.70</b>	18,043.80	109.10
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>76,681.50</b>	<b>95,950.60</b>	19,269.10	125.13
Үйл ажиллагааны орлого	4,000.00	14,440.60	10,440.60	361.02
Хадгаламжийн хүүгийн орлого	52,043.60	60,678.80	8,635.20	116.59
Шууд бус орлого	20,637.90	20,831.20	193.30	100.94
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>101,167.40</b>	<b>99,427.10</b>	-1,740.30	98.28
Бууны албан татвар	6,000.00	8,400.00	2,400.00	140.00
Малын хөлийн албан татвар	95,167.40	84,523.70	-10,643.70	88.82
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		6,503.40	6,503.40	#DIV/0!
<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>9,000.00</b>	<b>9,627.10</b>	627.10	106.97
Улсын тэмдэгтийн хураамж	1,000.00	1,457.40	457.40	145.74
Түгээмэл тархац		147.50	147.50	#DIV/0!
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.00	8,022.20	22.20	100.28
<b>Газрын төлбөр</b>	<b>4231</b>	<b>4048.3</b>	-182.70	95.68
Газрын төлбөр	4231	4,048.30	-182.70	95.68
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>7,257.00</b>	<b>7,327.60</b>	70.60	100.97
Ойн нөөц ашигласны төлбөр	4,057.00	3,208.80	-848.20	79.09
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	3,200.00	4,118.80	918.80	128.71
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,000.00</b>	<b>3,182.00</b>	<b>-1,818.00</b>	63.64
Нийтлэг татварын бус орлого	<b>5,000.00</b>	<b>3,182.00</b>	<b>-1,818.00</b>	63.64
хүү, торгуулийн орлого	5,000.00	3,182.00	-1,818.00	63.64

Сумын төсөвт 13 нэр төрлийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт дүнгээрээ 219,562.7 мянган төгрөгөөр буюу 107.9 хувиар давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 10440.6, хадгаламжийн хүүгийн орлого 8635.2, шууд бус орлого 193.3, бууны албан татвар 2400.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол хөрөнгийн орлогын 6503.4 мянган төгрөг нь төлөвлөгдөөгүй орлого орсон байна. Малын тоо толгойн албан татвар 10643.7, газрын төлбөр 182.7, ойн нөөц ашигласны төлбөр 848.2, хүү торгууль 1818.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээнд зориулан 2,359,607.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,197,057.1 сая төгрөгийг урсгал зардалд, 162,550.4 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,359,607.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээс 1,247,094.2, орон нутгийн төсвөөс 794,003.7, орон нутгийн хөгжлийн сангаас 49,412.7, эрүүл мэндийн даатгалын сангаас 28,600.0, үндсэн үйл ажиллагааны орлогоос 73,952.0, урьд оны санхүүжилтээс 166,544.9 мянган төгрөгийг орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,224,232.3, орон нутгийн төсвөөс 729,456.5, орон нутгийн хөгжлийн сангаас 49,412.7, эрүүл мэндийн даатгалын сангаас 16736.9 үйл ажиллагааны орлогоос 106,787.2 нийт 2,126,625.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 106,787.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 332,835.2 мянган төгрөгөөр давж биелсэн сум хөгжүүлэх сангийн орлого орсонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2145304.4 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой цалингийн зардал 27429.1, ндш 7089.8, байр ашиглалт 6039.8, хангамж 5393.3, норматив зардал 5187.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан орон нутгийн орлогод 28048.9, улсын төсөвт 22861.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар ЗДТГ-т 1384.0, ИТХ 250.0 нийт 1634.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 23665.5, дээд шатны төсвийн захирагчаас 216265.9, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22966.8 нийт 264532.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 46208.3, НДШ 5757.4, хангамжийн материалд 25446.8, норматив зардалд 68327.5, эд хогшил, урсгал засварт 43728.8, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 11374.8, бараа үйлчилгээний зардалд 26734.6 урсгал шилжүүлэгт 30580.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 180.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 141 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 554.0 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	554.0	3	554.0			100

Нийт									
------	--	--	--	--	--	--	--	--	--

/сая төгрөг/

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдаж, байгаль хамгаалах сан, ЖДҮДС гэсэн 2 сан нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5 дүгнэлт өгсөн байна.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд: Сумын ЗДТГ-ын аудит хийсэн санхүүгийн тайлангаас дахин үнэлгээний нөөцийн эхний үлдэгдэл 488.1 мянган төгрөгийг зөрүүтэй нэгтгэсэн нь өмнөх онд сангийн яамны е-тайланд зөрүүтэй нэгтгэсэнээс шалтгаалж тайлант онд залруулах боломжгүй байна.

#### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар нийт 231,409.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлсний 10,643.7 мянган төгрөгийн зөрчил 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлээ.

- Сумын ИТХ-ын 2020 оны 04 дүгээр тогтоолоор малын тоо толгойн албан татварыг тогтоож, 2021 онд 95167.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр баталж гүйцэтгэлээр 84523.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, 10643.7 мянган төгрөгийн татварыг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Төвлөрүүлсэн захирагчид 220,765.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 587065.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 33703.9 мянган төгрөгийг аудитын явцад залруулж, 1068.6 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 510160.0 мянган төгрөгт 9 албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 42132.4 мянган төгрөгийн зөрчилд 12 зөвлөмжийг хүргүүлээ.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд орлогын биелэлт их хэмжээгээр давсан орлогын төлөвлөлтийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 4.1 Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 16638.2 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 10440.6, хадгаламжийн хүүгийн орлого 8635.2 мянган төгрөгөөр давж биелсэн, хөрөнгө борлуулсны орлого төлөвлөөгүй 6503.4 мянган төгрөгийн орлого орсон нь гол нөлөө үзүүлсэн байна. Харин Малын тоо толгойн албан татвар 10643.7, ойн нөөц ашигласны төлбөр 848.2, хүү торгуулийн орлого 1818.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна

Энэ нь "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, 41.2.1-д хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх заалтыг хэрэгжүүлээгүй зөрчсөн байна.

4.1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль. 41 дүгээр зүйл. 41.2.1-д хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, Төсвийн орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.

4.1.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

#### **4.2 Дотоод хяналттай холбоотой асуудал**

4.2.1 Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 587065 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 1068.6 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 510160.0 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 42132.4 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнээс сум хөгжүүлэх сангийн 187966.7 мянган төгрөгийн авлагын журналын бичилт хийгээгүй, ОНХС-гаас бэлтгэсэн 32799.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагад шилжүүлэхдээ НБББББ-ын 4.6, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2.2 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын төсвийн захирагч, нягтлан бодогч нар, санхүүгийн албаны даргын сахилга хариуцлагыг дээшлүүлж, хууль, журмыг мөрдөж, санхүүгийн тайланг алдаагүй үнэн зөв илэрхийлж, өмнөх аудитаар гарсан алдааг давтан гаргахгүй ажиллах.

4.2.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

#### **4.3 Шилэн данстай холбоотой асуудал**

4.3.1 Илрүүлэлт: Тус байгууллагын 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд 141 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

4.3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж хэвших.

4.3.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.